

Дотуур утас ашиглах заавар

Гарчиг

Танилцуулга	3
IP утас ашиглах заавар	3
GXP-1400 IP утсыг ашиглах заавар	4
Сүлжээнд холбох заавар.....	4
Дэлгэцийн төлөв.....	5
Утсан дээр байрлах товчлуурууд	6
Дуудлага хийх	8
Дуудлага хүлээн авах	8
Дуудлагын түүх харах.....	8
Дугаар хадгалах, хадгалсан дугаар харах.....	8
DND буюу “Бүү саад бол” горим	8
Дуудлага шилжүүлэх	8
ATCOM-530 IP утсыг ашиглах заавар	8
Сүлжээнд холбох заавар.....	9
Дэлгэцийн төлөв.....	9
Утасны товчлуурууд	10
Дуудлага хийх болон хүлээн авах.....	11
Дуудлагын түүх харах.....	11
Дугаар хадгалах, хадгалсан дугаар харах.....	11
Дуудлага шилжүүлэх	12
Холбоо барих.....	12

Танилцуулга

Мэдээллийн технологийн алба нь МУИС-д компьютерийн дотоод сүлжээг ашиглан “Voice over IP” технологид суурилсан холбооны системийг нэвтрүүлээд багагүй хугацаа өнгөрч байгаа билээ. Одоогийн байдлаар нийт 400 орчим утас сургуулийн захиргаа, бүрэлдэхүүн сургуулиуд дээр тавигдсан бөгөөд эдгээр нь хоорондоо **үнэгүй, цагийн хязгаарлалтгүй** ярих боломжтой.

Харин гадагшаа дуудлага хийх, гаднаас дуудлага хүлээн авахад Юнивишн ХХК-ийн **77307730** болон Мобинэт ХХК-ийн **75754400** дугаарын давхар гарцыг ашиглаж байна. Давхар гарц ашигласнаар аль нэгэнд нь гэмтэл гарахад нөгөө гарцаар дуудлага хийх найдвартай ажиллагааг бий болгохоос гадна санхүүгийн хувьд хэмнэлттэй болсон.

Гадагшаа дуудлага хийхдээ залгах утасныхаа дугаарыг оруулан шууд дуудаж ярих ба гаднаас МУИС-ийн дотуур утасруу дээрх 2 гарцын алианаар нь ч дуудлага хийх боломжтой. Өөрөөр хэлбэл 77307730 эсвэл 75754400 дугаарлуу залгаад автомат хариулагчийн зааврын дагуу холбогдох дотуур утасны дугаараа оруулж ярина.

МУИС-ийн дотуур утаснаас гадны утасруу залгахад төлбөртэй учир утас бүрт тодорхой хэмжээний хязгаар тогтоосон ба уг хязгаарыг бүрэлдэхүүн сургуулиудын захиргаанаас тогтоодог. Доорх хүснэгтээр үнийн тарифийг үзүүлээ.

Ярианы тариф /НӨТ-ороогүй/		
Дотуур утас		0 төг/мин
Суурин утас	Мобинэт сүлжээнд <i>/7575XXXX/</i>	0 төг/мин
	Бусад сүлжээнд	15 төг/мин (60 сек алхам)
Үүрэн утас	Бүх сүлжээнд	30 төг/мин (60+1 сек алхам)
Лавлах утас -109		9 төг/мин

IP утас ашиглах заавар


МУИС-д одоогоор **atcom-530** болон **gxp-1400** серийн 2 төрлийн IP утас ашиглаж байна



GXP-1400 IP утсыг ашиглах заавар



Сүлжээнд холбох заавар



1. **PC** – утсаараа дамжуулан интернэт хэрэглэх бол компьютерт залгасан кабелийн нэг үзүүрийг энд залгана.
2. **LAN** – гаднаас буюу свичнээс ирсэн кабелийн нэг үзүүрийг залгана.

3. **DC** – тэжээлийн залгуур (adapter) залгана. /5V/
4. **Headset** – харилцуур залгана
5. **Headset** – харилцуур залгана

Анхаар: Тэжээлийн залгуур, сүлжээний кабелиудыг зөвхөн зааврын дагуу холбохыг анхаарна уу.









Дэлгэцийн төлөв



1. Он, сар, өдөр
2. Цаг
3. **Сүлжээний төлөв**
 - a. **Grandstream** – сүлжээ хэвийн ажиллаж байна
 - b. **Network Down** – сүлжээнд холбогдоогүй байна, **энэ тохиолдолд** гаднаас ирсэн сүлжээний кабелийн үзүүр утасны LAN портонд холбогдсон, нөгөө үзүүр нь свичид холбоотой байгаа эсэхийг шалгана
 - c. **Please Use 5V Power** – буруу тэжээлийн залгуур залгасан байна, **энэ тохиолдолд** 5V-ийн тэжээл залгана уу
 - d. **New Missed Calls** – хариулаагүй дуудлагын тоо

- e. **Keypad is locked** – од товчоор утасны товчлуурыг түгжсэн байна, *энэ тохиолдолд* од товч дээр удаан дарж түгжээг тайлна.

4. Утасны төлөв







- a.  - Серверт холбогдож, хаяг авсан.
- b.  - Серверт холбогдоогүй байна.
- c.  - Харилцуурыг авсан байна.
- d.  - Чанга яригч ажиллаж байна.
- e.  - Чихэвч залгасан байна.
- f.  - Дуудлага хийж байх үед түр хүлээлгэх горимд байна.
- g.  - Бүх дуудлагыг өөр дугаарлуу шилжүүлнэ.
- h.  - DND буюу “Бүү саад бол” горимд байна.

5. Дэлгэц дээрх товчлуурууд

- a. **NextScr** – IP хаяг, утасны дугаар, цаг агаарын мэдээлэл хооронд шилжинэ.
- b. **Redial** – сүүлийн залгасан дугаарлуу дахин залгана.
- c. **Missed** – хариулаагүй дуудлагуудыг харна.
- d. **FwdAll** – ирсэн дуудлагуудыг шилжүүлэх утасны дугаарыг оруулна.
- e. **EndCall** – дуудлагыг таслана.

Утсан дээр байрлах товчлуурууд



1. **HOLD** - дуудлага хийж байх үед түр хүлээлгэх горимд оруулна.
2. **TRANSFER** - одоо ярьж байгаа дуудлагыг өөр дугаарлуу шилжүүлэх
3. **CONF** -
4. **LINE 1 / LINE 2** - 2 шугамын хооронд шилжинэ.
5.  - ярьж байгаа үед дуугүй горимд шилжинэ, яриагүй үед DND горимд орно.
6.  - чихэвч хэрэглэж байгаа үед дуудлагыг авна, тасална.
7.  - чанга яригч дээр тавина.
8.  - харилцуураар ярина.
9.  - 4 талын товчлуур дээш, доош, баруун, зүүн тийш шилжинэ. Голын товч дээр дарснаар цэсрүү орно.
10.  - дууг ихэсгэж, багасгана.

11. **0-9,*,#** - стандарт утасны товчлуурууд.

Дуудлага хийх

GXP1400 утас нь харилцуур, чихэвч, чанга яригчаар ярьж болох ба дуудлагын үеэр тохирох товчлуурыг дарснаар тэдгээрийн хооронд шилжих боломжтой.

Дуудлага хийхдээ харилцах утасны дугаараа оруулаад  товчийг дарна.

Уг утсан дээр 2 дугаар зэрэг бүртгэж болох ба аль шугамаар ярихыг сонгохдоо тохирох дугаартай **LINE 1 / LINE 2** товчийг дарна.

Дуудлага хүлээн авах

Дуудлага ирэхэд утас дугарахаас гадна дуудлага ирж буй шугамын гэрэл улаан өнгөөр анивчина.

Харилцуурыг авах эсвэл **SPEAKER, HEADSET** товчнуудыг дарснаар дуудлагыг авна.

Утсаар ярьж байхад давхар дуудлага орж ирэх үед дуудлага ирж буй шугамын **LINE** товчийг дарснаар дуудлагыг авах ба өмнөх дуудлага **HOLD** буюу түр хүлээх горимд шилжинэ.

Дуудлагын түүх харах

Голын товчин дээр дарж **MENU**-руу орох ба хамгийн эхэнд байгаа **Call History**-г сонгоно.

Хариулсан-**recieved**, хариулаагүй-**missed**, гадагшаа хийсэн-**dialed**, шилжүүлсэн-**forwarded** гэх мэт бүх дуудлагын түүхийг харж болно.





Дугаар хадгалах, хадгалсан дугаар харах

Голын товчин дээр дарж **MENU**-руу орно. Доош гүйлгэж **Phonebook**-ийг сонгоно. Энд хадгалсан дугаарууд байх ба **New Entry**-г сонгож шинэ дугаар хадгална.

DND буюу “Бүү саад бол” горим

Дуудлага хүлээж авах боломжгүй үедээ **DND** горимыг сонговол ирсэн дуудлага шууд дуут шууданд холбогдно.

MENU-руу орж доош гүйлгээд **Preference**-ийг сонгоно. Эндээс **Do Not Disturb**-ийг сонгож **enable** болгоно.

Ингэснээр дэлгэц дээр  тэмдэглэгээ харагдна. Мөн утасны товчлуур дээрээс  товчийг дарж **DND** горимд орж мөн болиулж болно.

Дуудлага шилжүүлэх

Дуудлага ирж байх үед (мөн ярьж байх үед) **TRANSFER** товчийг дарж тухайн дуудлагыг шилжүүлэх утасны дугаараа оруулаад **#** товчийг дарснаар дуудлагыг шилжүүлэх боломжтой.

ATCOM-530 IP утсыг ашиглах заавар



Сүлжээнд холбох заавар



1. **DC** – тэжээлийн залгуур (adapter) залгана. /12V 500mA/
2. **WAN** – гаднаас буюу свичнээс ирсэн сүлжээний кабелийн нэг үзүүрийг залгана.
3. **LAN** – утсаараа дамжуулан интернэт хэрэглэх бол компьютерт залгасан кабелийн нэг үзүүрийг энд залгана.

Анхаар: Тэжээлийн залгуур, сүлжээний кабелиудыг зөвхөн зааврын дагуу холбохыг анхаарна уу.

Дэлгэцийн төлөв

1. **Хэвийн**
 - a. Таны нэр эсвэл утасны дугаар
 - b. Огноо, цаг



2. **Logon SIP Fail, Retrying...** - серверт холбогдож чадахгүй байна, **энэ тохиолдолд** гаднаас ирсэн сүлжээний кабелийн үзүүр утасны WAN портонд холбогдсон, нөгөө үзүүр нь свичид холбоотой байгаа эсэхийг шалгана. Холбоотой байвал Sysinfo товчийг дарж -DHCP- хэсэгт байгаа хаягийг MTA-нд мэдэгдэж шалгуулна.
3. **DHCP N/A, Retrying...** - сүлжээнд холбогдоогүй байна, **энэ тохиолдолд** гаднаас ирсэн сүлжээний кабелийн үзүүр утасны WAN портонд холбогдсон, нөгөө үзүүр нь свичид холбоотой байгаа эсэхийг шалгана.
4. **WAN IP conflict...** – хаяг давхардсан байна, **энэ тохиолдолд** утасны тэжээлийн кабелийг салгаад буцаагаад залгана уу.
5. **Missed Calls XX** – энэ нь таны утсанд ирсэн хариулаагүй дуудлагын тоог заана.

Утасны товчлуурууд



1. **Menu/OK** – тохиргоо хийх ба энэ хэсэгрүү хэрэглэгч орох хэрэггүй, мөн бусад цэстэй ажиллах үед OK командаар ашиглана.
2. **Modify** – өөрчлөх
3. **Exit** – гарах
4. **Sysinfo** – сүлжээний тухай мэдээлэл.
 - a. **Number** – утасны дугаар
 - b. **DHCP** – сүлжээнээс авсан IP хаяг
 - c. **SIP Server** – холбогдсон серверийн нэр, хаяг
 - d. **Gateway** – сүлжээний гарц
 - e. **Netmask** – сүлжээний маск
 - f. **SIP** – серверт холбогдсон бол “registered”

5. **Up** – дээш нь гүйлгэх
6. **Down** – доош нь гүйлгэх
7. **Out call** – гадагшаа хийсэн дуудлагын түүх
8. **In call** – гаднаас ирсэн дуудлагын түүх
 - a. **Missed** - хариулаагүй
 - b. **Received** - хариулсан
9. **Pbook** – дугаар хадгалах, хадгалсан дугаарууд харах.
 - a. **Current** – хадгалсан дугаарууд
 - b. **Add** – дугаар шинээр хадгалах
 - c. **Search** – дугаар хайх
10. **FWD** – Дуудлага шилжүүлэх
11. **Hold** – хүлээлгэх горимд шилжих
12. **Record** – бичлэг хийх
13. **Send** – дугаараа оруулаад send товчийг дарвал тодорхой хугацааны хүлээлтгүй шууд дуудаж эхэлнэ.
14. **Vol+** - дуу нэмнэ
15. **Vol-** - дуу багасгана
16. **Redial** – сүүлийн залгасан дугаарлуу дахин залгана
17. **Mute** – чимээгүй горим
18. **Del** – устгах
19. **Handfree** – чанга яригч дээр тавих
20. **0-9, *, #** - стандарт утасны товчлуурууд

Дуудлага хийх болон хүлээн авах

Дуудлага хийх болон хүлээн авахад харилцуур болон чанга яригчийг ашиглах боломжтой. Чанга яригчийг ашиглах бол **Handsfree** товчийг дарна.

Дуудлага хийхдээ утасны дугаарыг оруулаад **Send** товчийг дарна.

Хамгийн сүүлийн залгасан дугаарлуу дахин залгах бол **Redial** товчийг дарна.

Дуудлагын түүх харах

Гадагшаа залгасан дугаарыг харахдаа **OutCall** товчийг дарж **Up** болон **Down** товчоор гүйлгэнэ.

InCall товчийг дарснаар **Missed** болон **Received** гэсэн сонголт байх ба хариулаагүй дуудлагыг харахдаа **Missed** –ийг сонгож **OK** дарна.

Хүлээн авсан дуудлагыг харахдаа **Received** сонголтыг хийнэ.

Дугаар хадгалах, хадгалсан дугаар харах

Pbook товч дээр дарж дугаар харах бол **Current** сонголтыг хийнэ.

Хайх бол **Search** сонголтыг хийж хайх нэрээ оруулна.

Дугаар нэмж хадгалах бол **Add** сонголтыг хийгээд нэр болон дугаараа оруулж хадгална.

Дуудлага шилжүүлэх

Дуудлага ирж байх үед (мөн ярьж байх үед) **FWD** товчийг дарж тухайн дуудлагыг шилжүүлэх утасны дугаараа оруулаад **Send** товчийг дарснаар дуудлагыг шилжүүлэх боломжтой

Холбоо барих

Та дээрх зааврын дагуу дотуур утсаа ашиглахад ямар нэг тодорхойгүй асуудал гарвал Мэдээллийн Технологийн Албаны 1154, 1155 дотуур утас болон 312829 дугаарын утсаар холбоо барихаас гадна утсаа хичээлийн 1-р байрны 120 тоотод авч ирнэ үү.

**Бидэнтэй хамтран ажилласанд баярлалаа.
Мэдээллийн Технологийн Алба**